

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Ерөнхий мэдээлэл

Станцын нэр:

“ГОВЬ” 30МВт нарны цахилгаан станц

Байгууллага :

“Дезерт солар пауэр вуан” ХХК

Улсын бүртгэлийн дугаар:

9019071103

Аж ахуйн нэгж байгууллагын регистрийн дугаар:

5708338

Байгууллагын хаяг:

Улаанбаатар хот – 14251 Сүхбаатар дүүрэг

1-р хороо , Сөүлийн гудамж, Сити плаза

307 тоот Утас: 976-88187720

E-mail: cd@unitedgreen.com


1.2. Станцын зорилго, ач холбогдол

Тус нарны цахилгаан станцыг барихдаа байгаль орчинд сөрөг нөлөөгүй, орчин үеийн дэвшилтэд техник, технологийн шийдлийг сонгохын зэрэгцээ Сайншандад шинээр баригдаж буй “Газрын тосны үйлддвэр” болон Сайншандын оршин суугчдын тодорхой хэсгийг цахилгаан эрчим хүчээр хангахад оршино. Түүнээс гадна, тус станцыг урт хугацаанд тогтвортой ажиллуулснаар шинэ ажлын байр бий болгох, татварын орлогоор дамжин улс, орон нутгийн төсвийг нэмэгдүүлэх зэрэг ач холбогдолтой.

1.3. Станцын байршил, дэд бүтцийн хөгжлийн байдал

“Дезерт солар пауэр вуан” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Сайншандын нарны цахилгаан станц” нь байршлын хувьд Монгол орны зүүн өмнөд хэсэгт Сайншанд хотын хажууд байрлалтай. Ойролцоогоор 80 га ашиглагдаагүй талбайд нарны цахилгаан станцыг байгуулсан болно. Тус станцын талбай нь далайн түвшнээс дээш ойролцоогоор 940 метр өндөрт өргөгдсөн, Сайншанд хотоос зүүн урд зүгт 5,6 км зайд орших бөгөөд ерөнхийдөө тэгш гадаргуу дээр байрлана. Энэ нутаг дэвсгэрт өвс, ургамал маш бага, тачир ургадаг онцлогтой.

Зураг 1. “Дезерт солар пауэр вуан” ХХК-ийн “Говь” 30МВт нарны цахилгаан станцын байршилыг Монгол орны газрын зураг дээр харуулбал





Зураг 2. “Дезерт солар пауэр вуан”
ХХК-ийн “Сайншандын нарны
цахилгаан станц”-ын байршил
сансарын зургаар харуулбал



Зураг 3. “Сайншандын нарны цахилгаан станц”-ын байршил
баруун өмнө зүгээс
харуулсан бөгөөд тухайн орчны байдал


“Дезерт солар пауэр вуан” ХХК нь “Сайншандын нарны цахилгаан станц”-ыг Сайншанд хотын ойролцоо хатуу хучилттай автозамд ойр, суурин болон үүрэн холбооны бүх операторуудын үйлчилгээ авах боломжтой, дэд бүтэц сайн хөгжсөн бүс нутагт хэрэгжүүлсэн. Өнөөдрийн байдлаар тус цахилгаан станц нь бүрэн гүйцэд баригдан туршилт, тохируулга хийгдэн **2020 оны 10 дугаар сарын 16** нд улсын комиссын шийдвэрээр ашиглалтад орж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа явуулах эрх нь нээгдсэн. Энэ үеэс эхлэн монгол улсын эрчим хүчний нэгдсэн сүлжээнд өөрийн бүтээгдэхүүнээ тасралтгүй нийлүүлж байна. Одоогийн байдлаар нийт 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажил үүргээ гүйцэтгэж 2026 онд төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд **51,1 сая квт /цаг** эрчим хүчийг төлөвлөгөөний дагуу нийлүүлнэ.

1.4. Станцынн хүчин чадал, төлөвлөлт, технологийн сонголт

“Дезерт солар пауэр вуан” ХХК-ийн “Сайншандын нарны цахилгаан станц”-ын хүчин чадал болон бусад гол үзүүлэлтүүдийг доорх хүснэгтээр харуулав.

Станцын гол үзүүлэлтүүд

Тодорхойлолт		Нарны цахилгаан станц
Хүчин чадал	МВт	29.568
Эрчим хүч/1 жилд	МВтц/жил	52,276
Хөрөнгө оруулалт	сая \$	75.85
Станцын талбай	м ²	714 000
Өгөөж/1.жилд	кВтц/кВ	1,768
Хувь/1.жилд	%	85.0
Загварын нийт тоо	ширхэг	110 880
Төв хувиргагчийн нийт тоо	ширхэг	40



Зураг 4. “Сайншандын нарны цахилгаан станц”-н нарны панелүүдийн ерөнхий төлөвлөлт

Тус нарны цахилгаан станцад доор дурдсан үндсэн болон туслах тоног төхөөрөмж, материал, барилга байгууламжууд байна. Үүнд:

- Тус бүр 270 Вт чадалтай - **110880 ш** нарны дэлгэц
- Нарны дэлгэцийн суурь - **1260 ком**
- Тогтмол гүйдлийн холболтын хайрцаг – **160 ш**
- Тус бүр 630 кВт-ын чадалтай - **40 инвертор**
- Тус бүр 2750 кВА чадалтай 35 кВ-ын трансформатор – **10 ш**
- Хувьсах гүйдлийн кабель – **5 км**
- Тогтмол гүйдлийн кабель – **48 км**
- Дэд станц - **1 ком**
- 35 кВ-ын таслуур - **10 ш**
- Дотор байрлах 35 кВ-ын таслуур - **8 ш**
- 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам - **13,8 км**
- Хяналт, хамгаалалтын систем – **1 ком**
- Харуулын байр – **1 ком**
- Гүний өрмийн худаг **1 ком** зэрэг орно .

2. СТАНЦЫН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Тус станцын байршил, техник, технологийн шийдэл, төлөвлөлт болон төсөл хэрэгжих үеийн байгаль орчны асуудлыг үнэлэхдээ тухайн төслийн онцлогт тохируулан магадлан жагсаалтын аргыг боловсруулж ашигласан бөгөөд тухайн асуудлын хэр төлөвлөгдсөн байдлыг сайн, дунд, муу гэсэн байдлаар, харин сөрөг нөлөөлөл байгаа эсэх (тийм/үгүй), хэрвээ байгаа (тийм) бол сөрөг нөлөөллийн үр дагавар нь хэр болохыг бага, дунд, их гэсэн утгуудын аль тохирох дээр “х”-ээр тэмдэглэж, үнэлж дүгнэсэн болно.

Станцын байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон болзошгүй нөлөөллийн магадлан жагсаалт.



Станцын байршил, шийдэл,төлөвлөлттэй холбоотой асуудлууд	Төлөвлөгдсөн байдал			Сөрөг нөлөөлөл байгаа эсэх	Нөлөөллийн үр дагавар		
	Сайн	Дунд	Муу		Сайн	Дунд	Муу
1.Станцын байршилтай холбогдох асуудал							
Өмнө нь ямар нэг төсөл хэрэгжиж байгаагүй онгон зэлүүд газарт хэрэгжих эсэх				Үгүй			
Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй төв, суурин газар байгаа эсэх				Тийм	х		
Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр болон түүний ойр орчимд эмнэлэг, сургууль, төрийн байгууллага, орон нутгийн нийтийн үйлчилгээний барилга байгууламж зэрэг нүүлгэн шилжүүлэхэд хүндрэл учруулахуйц сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй олон нийтийн байгууллага байгаа эсэх	х			Үгүй			
Үерийн усны ам газар эсэх				Тийм		х	

Мөн үйлдвэрлэлийн осол, гал түймрээс хамгаалах асуудлуудыг тодорхой хэмжээнд төлөвлөсөн.

Станцын байршил, шийдэл, төлөвлөлттэй холбоотой асуудлууд	Төлөвлөгдсөн байдал			Сөрөг нөлөөлөл байгаа эсэх	Нөлөөллийн үр дагавар		
	Сайн	Дунд	Муу		Сайн	Дунд	Муу
2. Станцын шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой асуудал							
Үйл ажиллагааны болон ашиглалтын чанар нь тухайн орон нутагт нийцтэй эсэх	х			Үгүй			
Төслийн техник технологийн шийдлийг техник эдийн засгийн хувьд олон хувилбараас авч үзэн аль болох оновчтой аргыг сонгосон эсэх	х			Тийм			
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон гал түймрээс хамгаалах асуудал хир зэрэг төлөвлөгдсөн	х			Тийм	х		
Тусгай анхаарал тавих шаардлагатай хорт хий, тоос, утаа гардаг эсэх	х			Үгүй			
Барилга байгууламж барих үед усны эх үүсвэр, нөөц бохирдох эсэх	х			Үгүй			
3.Төсөл хэрэгжих үеийн зарим асуудал							
Станцын үйл ажиллагааны болон ашиглалтын чанарын талаарх төлөвлөгөө, санхүүжилт хир зэрэг бодитой, шаардлага хангасан эсэх	х						
Мэргэжлээс шалтгаалах өвчин болон аюулгүй ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилт бодитой эсэх	х						
Орчныг тохьжуулах, нөхөн сэргээх төлөвлөгөө хэр тусгагдсан эсэх (хөрсжүүлэх, ургамал тарих гэх мэт)	х						

Геологийн тогтоц, физик газарзүйн онцлог, тэдгээртэй холбоотой болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ:

Тус станцын үйл ажиллагааны хүрээнд ямарваа нэгэн эрдэс баялаг ашиглах болон геологийн тогтоц, геоморфологийн төрх байдлыг өөрчлөх үйл ажиллагаа явагдахгүй тул тус станцын зүгээс тэдгээрт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага байна.

Тус төсөл хэрэгжих бүс нутаг нь аль хэдийн байгалийн үзэсгэлэн төрх байдлаа алдаж, төв суурин газрын эдэлбэр нутаг дэвсгэрт хамаарах болсон байна.

Геологийн тогтоц, геоморфологи, ландшафтад үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Болзошгүй гол сөрөг нөлөөллийн цар хүрээ, үргэлжлэх хугацаа, эрчим							
	Шууд	Шууд бус	Богино хугацааны	Ург хугацааны	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг	Нөлөөлөл байхгүй
Байгалийн геологийн тогтоцыг өөрчлөх				х				х
Байгалийн үнэт, ховор чулуу, чулуулаг, хурдас болон бусад байгалийн нөөц, баялаг ашиглах								х
Байгалийн геоморфологийн төрх байдлыг эвдэх, өөрчлөх	х			х				х
Байгалийн өвөрмөц, содон тогтоцтой хад чулуу, уул ус, намгархаг газар зэрэгт сөргөөр нөлөөлөх								х
Байгалийн үзэсгэлэнт төрх байдал өөрчлөгдөх	х			х			х	
Ландшафтын хэлбэр, төрх байдал өөрчлөгдөх				х			х	

Хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ:

“Дезерт солар пауэр вуан” ХХК-ийн Дорноговь аймгийн Сайншанд суманд хэрэгжүүлсэн “Говь 30МВт нарны цахилгаан станц”-ын талбай нь хөрс газарзүйн мужлалаар Төв Азийн хөрс-био уур амьсгалын их мужийн Говийн их мужийн өргөргийн бүсшилийн хэв шинж бүхий Дорноговийн 12-р тойрогт, хуурай хээр болон говийн бүсийн зааг болох заримдаг цөлийн цайвар бор хөрсний тархалтын томоохон бүсэд хамаарах бөгөөд хөрсөн бүрхүүлийн хувьд жигд тархалттай гадаргын хэлбэр дүрс, өндөршилөөс шалтгаалан хэв шинж хувирахгүй, тэгш талархаг бүс нутгуудаар заримдаг цөлийн цайвар бор хөрс, түүний хэв шинжүүд өргөн тохиолдох бол нам дор, хотос газруудаар мараалаг, хужирлаг хөрсний хэв шинж өргөн тохиолдоно. Бүс нутгийн хувьд хөрсний механик бүрэлдэхүүнээрээ хөнгөн шавранцар, янз бүрийн байх боловч элсэрхэг хөрс зонхилно.

Хөрсний үржил шимээр ядуулаг, сайр чулуун хучаастай, хүнд шавранцар механик бүрэлдэхүүнтэй. Тус станцын талбай нь өмнө байгуулагдсан “Сайншанд салхин цахилгаан станц төсөл”-тэй ойрхон орших тул энэ төслийн бүтээн байгуулалт болон Сайншанд хотоос ойролцоох сумд, Замын-Үүдийн улсын чанартай зам руу чиглэсэн шороон замууд олноор үүсэж тус станцын талбайн хөрсөн бүрхэвчийг ихээхэн доройтолд оруулснаас гадна, хуучин ашиглаж байсан шороон замууд, энэ төслийн бүтээн байгуулалт, үйл ажиллагаатай холбоотойгоор шинэ замууд ихээр гарч тухайн орчны хөрсөн бүрхэвчийг нилээд талхалж, доройтуулсны дээр мөн салхи, ус гэх мэт байгалийн хүчин зүйлүүд тодорхой хэмжээгээр нөлөөлж буй байдал ажиглагдаж байна.

Цаашид тус станцын үйл ажиллагаанд ашиглаж буй машин техникийн шатах, тослох материалын хаягдал, тоног төхөөрөмж, техник хэрэгслээс гарсан хаягдал, бохир ус, бүтээгдэхүүнийг эмх замбараагүй хаяснаас хөрс бохирдох, мөн ахуйн хог хаягдлыг ил задгай замбараагүй хаяснаар хөрсөн бүрхэвчид бохирдол үүсгэж, улмаар хорт бодис хөрс, хөрсний усаар дамжин хүн болон бусад амьд организмд сөргөөр нөлөөлөх зэрэг эрсдэл байх бөгөөд тус тайланд тусгагдсан холбогдох журам, стандартын дагуу хог хаягдлыг цуглуулан хадгалж, зайлуулж устгах шаардлагатай.

Хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим



Болзошгүй сөрөг нөлөөлөл	Болзошгүй гол сөрөг нөлөөллийн цар хүрээ, үргэлжлэх хугацаа, эрчим							
	Шууд	Шууд бус	Богино хугацааны	Урт хугацааны	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг	Нөлөөлөл байхгүй
Тус төслийг хэрэгжүүлснээр төслийн эзэмшлийн талбайн үржил шимт өнгөн хөрс устаж үгүй болох				х				х
Барилга байгууламж, машин, техник болон хүний хөл хөдөлгөөний улмаас хөрсний өнгөн хэсэг талхагдаж халцрах	х			х			х	
Төслийн үйл ажиллагааны улмаас хөрсөн бүрхэвч эвдэрч, хөрсний суулт, гулсалт үүсэж, элэгдэлд орох								х
Машин техникийн шатах, тослох материалын хаягдал, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг угаасан бохир ус зэргээр хөрс бохирдох	х			х			х	
Химийн бодис асгарах, хаягдал ус, хог хаягдлыг эмх замбараагүй хаяснаас хөрс бохирдох	х			х			х	
Ахуйн хог хаягдлыг ил задгай замбараагүй хаяснаар хөрсөн бүрхэвчид бохирдол үүсэх	х			х				х
Хорт бодис хөрс, хөрсний усаар дамжин хүн болон бусад амьд организмд сөргөөр нөлөөлөх								х
Аадар бороо, цасны шар усны үер ихээр бууж үерийн усны улмаас хөрс угаагдаж, үржил шимт давхарга багасах, хөрс элэгдэж, эвдрэх	х		х				х	

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежмент төлөвлөгөө (БОМТ) нь албан ёсны баримт бичиг бөгөөд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө юм. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд станцын үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн. Энэ төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн товч тодорхойлолт бөгөөд жил бүр хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай. Ингэхдээ үр дагавар, бодит байдалтай уялдуулан улам баяжуулж, сайжруулан мөрдлөг болгох хэрэгтэй. Станцын болон түүний нөлөөллийн бүс дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд мониторинг үнэлгээ хийх шаардлагатай. Энэхүү төлөвлөгөө нь тухайн байгууллагын жил бүрийн байгаль орчин хамгаалах төлөвлөгөө боловсруулахад ашиглагдах баримт бичиг болно.

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтыг станцын эдэлбэр газрын ургамалын нөмрөгт мониторинг үнэлгээ хийлгүүлэн ашиглалтын явцад ургамалын төлөв байдлын үнэлгээ ямар байгааг тодорхойлуулан цаашид авах шаардлагатай арга хэмжээнүүдийг оновчтой төлөвлөх явдал гэж төлөвлөсөн болно



4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Усны чанар , нөөцөд үзүүлж болзошгүй нөлөөлөл

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төг /	Тоо хэмжээ	Нийт зардал, /,төг /	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Усны нөөц хомсдох, бохирдох	Усаа тоолуураар хянаж , хэмнэлттэй зарцуулах / Худгийн усны тоолуурын ээлжит баталгаажуулалтыг хийлгэх /	72га газар	ширхэг	700 000	1	700 000	2026-03 сар	➤ Унд, ахуйн зориулалттай усны төвлөрсөн хангамжийн эх булгийг сонгох журам, эрүүл ахуйн шаардлага ➤ Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага ➤ Усны чанар, хаягдал ус. Техникийн ерөнхий шаардлага ➤ Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ
2.		Гүний худгийн орчныг хамгаалах , тохижуулах		ком	400 000	1	400 000	5 сар	
НИЙТ ДҮН							1 100 000		

Ундны усыг “Амин ус” цэвэр усны үйлдвэрээс аж ахуйн гэрээгээр нийлүүлэгддэг болно. Байгууллагын эзэмшил газарт ардын гар хийцтэй худаг уст цэг, гадаргын ус , булаг шанд байхгүй. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь усан орчинд нөлөөлөх нөлөөлөлгүй технологтой.

Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хариуцах ажилтан	Нэгжийн Зардал / төг /	Тоо хэмжээ	Нийт зардал, / төг /	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Агаар орчинд үзүүлэх нөлөө	Агаарын бохирдлыг мэргэжлийн байгууллагаар тодорхойлуулах Хянах үзүүлэлт: Агаар дахь тоосжилт PM10, Агаарын найрлага SO ₂ , NO ₂ , NOX.	Станцын хашаагаар хязгаарлагдана	Байгаль орчны ажилтан	90 000	1 удаа	90 000	02-р сард	Монгол улсын агаарын тухай хууль MNS 4585-2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
2.		Агаарт шатах тослох материалын ууршилт гаргахгүй байх, хатсан өвс, хуурай хог ил шатаахгүй байхыг мөрдлөг болгон ажиллах	Нийт талбай	Бүх албан хаагчид				Жилийн турш	
3.	Тоосжилт	Станцын талбайн замын сүлжээг зөв төлөвлөн тэмдэгжүүлэн тоосноос хамгаалж ажиллах	Нийт талбай	Ерөнхий инженер , Байгаль орчны ажилтан			Тодор - хойгүй	Тогтмол хэрэгжүүлэх	
НИЙТ ДҮН						90 000			

Хөрсөн орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал / төг /	Тоо хэмжээ	Нийт зардал, / төг /	Хэрэг-жүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Хөрсний эвдрэл ,ургамал талхлагдах	Станцын эдэлбэр газарт ургамалын нөмрөгт мониторинг үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	талбайн хэмжээнд	ком		1	3 300 000	8-р сард	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
2.		Ургамал нь талхлагдсан газруудад олон настын үр тариалж зүлэгжүүлэх ажлыг хийх	Станцын талбайн хэмжээнд	м ² кг	Хөрс бэлтгэх арчилгаа олон настын үр авах	100 10	450 000 462 000	6-р сар	
3.		Автозогсоолыг тохьжуулж байнга сайжруулах арга хэмжээг тухай бүр авах	талбайн хэмжээнд				550 000	7-р сар	
4.	Амьтдын амьдрах орчныг сайжруулах, эрсдлээс хамгаалах	Шувуу хамгаалах агаарын шугмын 2 тулгуурын хооронд харагдац сайтай тод өнгийн дохиолол 3-4ш байрлуулах	Станцын талбайн хэмжээнд	ш	100 000	5	500 000	6 сараас 10 –р сарын хооронд	
	НИЙТ ДҮН						5 262 000		

5. ОРЧНЫ ТОХЬЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэм - жих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн Зардал / төг /	Нийт зардал / төг /	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Станцын хашааны төв хаалганаас хуваарьлах байгууламж хүртэл тавих явган хүний замын хэсэг		м ²	100	88 800	8 880 000	8-р сарын 1-с	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
2.	Станцын талбайн хашаанд ногоон аяны хүрээнд мод тарьж ойн зурвас бий болгох, арчилж тордох	Ногоон байгууламжийн усалгаа болон ашиглалтын зардалын асуудлыг шийдвэрлэх • 100ш улиас 3өнастай худалдан авах • Бууц татах / 80м-с 18м³ / • Э ө • Модны нүх ухах / 100ш , Ø= 80*80см / • Еумины бордоо / 100л *13000төг / • Гербицидийн уусмал / 500гр-н а савлагаатай 25000төг , 50л усанд т найруулж автомаксаар шүршинэ / • Намрын уламжлалт мод тайралт х 500000төг + 325000 төг /				1 800 000 900 000 450 000 800 000 1 300 000 500 000 825 000	4-10 сар 10 сар эхээр	Монгол улсын Ерөнхийлөгчийн тэрбум мод тарих аян
НИЙТ ДҮН						15 455 000		

6. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал / төг /	Нийт зардал, / төг /	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Гал түймэр	Станцын талбайд гал түймрээс сэргийлэх, эрсдлийг бууруулах боломжтой бүх арга хэмжээг авах	Бүх байгууламж галын эрсдлээс хамгаалах хэрэгслээр тоноглогдсон	Шинээр суурилуулах шаардлага - гүй, хугацаа дууссаныг цэнэглэнэ	500 000	жилдээ	Галын аюулгүй байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/, 3 дугаар бүлэг Гамшгаас хамгаалах тухай хууль, 5 дугаар бүлэг
2.	Хүний эрүүл мэнд муудах	Байгууллагын зүгээс албан хаагчдын эрүүл мэндийг урьдчилан сэргийлж урьдчилсан эрүүл мэндийн үзлэгт хамруулан витаминжуулалтад хамруулах	2 удаа	1 024 650	2 049 300	Хавар болон намар	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 3, 4 дүгээр бүлэг
3.	Аянга цахилгаан	Станцын бүх тоног төхөөрөмж нь хамгаалалттай тул газардуулгын битүү хэлхээг хагас жил тутам шалгаж байх	2 удаа			4 ба 10-р сард	Эрчим хүчний салбарын байгууллагуудын техникийн аюулгүй ажиллагааны дүрэм .
НИЙТ ДҮН					2 549 300		

7. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, /төг /	Тоо хэмжээ	Нийт зардал, /төг /	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Бохир ус зайлуулах	“Чандмань-илч” ОНӨҮГазартай гэрээ байгуулан бохир усыг төвлөрсөн сүлжээнд асгана		Нэг ачилт	44 000	5	220 000	жилдээ	
2.	Ахуйн хог	Ахуйн хог хаягдлыг ангилан, зайлуулах гэрээг “Тохижилт-Сайншанд”ХТГ-тай хийх	Ажилчдын байр, тухайн бүсийн 50метр доторх бүс	Нэг ачилт	80 000	10	800 000	Жилийн турш	Хог хаягдлын тухай хууль Ариун цэврийн тухай хууль Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль (2006) болон MNS 5344:2003 стандарт
3.	Ажлын байрны гаднах хог хаягдал	Үерийн усны хаалт , үйл ажиллагаанаас гарах хог хаягдлын нөлөөллийн болзошгүй эх үүсвэрүүдийг тодорхойлох ангилах, зайлуулах							
4.	Ангилан ялгасан хуванцар хаягдлыг Сайншанд суманд үйл ажиллагаа явуулж байгаа “Эко говь” үйлдвэрт нийлүүлнэ.	“Эко говь” төслийн “Дэлгэрийн дэрс” ХХК-д ангилсан хог хаягдлыг тушаан , хэрэглээний зөв дадлыг хэвшүүлж , хог хаягдлын менежментийг сайжруулна.	Станцын хашаа түүнээс гадагш 50метр доторх бүс	кг	0	50-аас дээш	500 000	Жилийн турш	Хог хаягдлын тухай хууль
НИЙТ ДҮН							1 520 000		

8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт, шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, / төг /	Нийт зардал, / төг /	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Хөрсний шинжилгээ	Хяналтын цэг 44° 54' 33,2 ^{II} 110° 11' 16,0 ^{II} 44° 54' 39,4 ^{II} 110° 12' 04,9 ^{II}	Жилд нэг удаа 08-р сард	1.	140 000	140 000	Хөрсний төлөв, элэгдэл эвдрэлийн нөхцөл, ялзмаг %, рН, физик шинж чанар, органик бодис, карбонат, P ₂ O ₅ , зэргийг тодорхойлох Хөрсний давсжилт (CO ₃ , NO ₃ , SO ₄ , NH ₄)
2.	Агаар , тоосны шинжилгээ	– " –	8-р сард	1	90 000	90 000	Агаар (SO ₂ , NO ₂ , PM10, TPS) тодорхойлох
3.	Аж ахуйн ус	Гүний худгаас	8-р сард	1	80 000	80 000	Ундны усны стандарт MNS9000:2005
4.	Бохир ус	Хуваарьлах байгууламжийн цооног	8-р сард	1.	60 000	60 000	Усны рН, Цахилгаан дамжуулах чанар, Умбуур бодис, Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч, Нитрит, Нитрат, Аммоний азот, Хлорид, Холимог шүлтлэг, P ₂ O ₅ .
НИЙТ ДҮН						370 000	

**9.ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
1.	БОМТ –ний биелэлтийн явцыг байгууллагын удирдлагад мэдээлж байх.		Сар бүр	Байгаль орчны ажилтан	БО-ны мэргэжилтэн бүх бичиг баримтыг боловсруулна.БОМТ-ний биелэлтийн тайланг жилийн эцэст бичнэ.
2.	БОМТ-д өөрчлөлт оруулах , санхүүжилтын асуудлыг шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авах		Тухай бүр	Захирал Ер. Инженер БО-ны ажилтан	
3.	Шаардлагатай хууль тогтоомжийг судлах сурталчлах зорилгоор мэргэжлийн багаар богино хугацааны сургалт зохион байгуулах арга хэмжээ авах	450 000	9-р сард	БО-ны ажилтан ОНХариуцсан менежер	Мэргэжлийн байгууллагаас ажилтан урих
НИЙТ ДҮН		450 000			

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал (2026он)

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Нийт зардал /мян.төг/
Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ		
1	Усны чанар, нөөцөд үзүүлж болзошгүй нөлөөлөл	1 100 000
2	Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	90 000
3	Хөрсөн орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	5 262 000
ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ		15 455 000
ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ		2 549 300
ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ		1 520 000
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР		370 000
БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө		450 000
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал		26 796 300